



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/84

Булган сум

**Хүндэтгэл үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Улсын аварга малчин өрх", "Улсын аварга фермер", "Улсын аварга тариаланч", "Улсын аварга тариаланч хамт олон"-оор шалгарсан дараах аймгийн малчин, фермер, тариаланчдад хүндэтгэл үзүүлсүгэй. Үүнд:

"Улсын аварга малчин өрх"-өөр:

- Дашинчилэн сумын Лах багийн малчин Очирзавын Мөнхбат;
- Гурванбулаг сумын Агьт багийн малчин Нямсүрэнгийн Мөнхбат;
- Орхон сумын Халиун багийн малчин Бямбын Амгаланбаатар;
- Сайхан сумын Мануулт багийн малчин Пүрэвсүрэнгийн Болдбаатар;
- Хангал сумын Сөрт багийн малчин Бадарчийн Пүрэвжав;
- Могод сумын Баянгол багийн малчин Болдын Энхтүвшин
- Бүрэгхангай сумын Цахт багийн малчин Гэнэнгийн Ядам
- Тэшиг сумын Хужирт багийн малчин Эрдэнэ-Очир

"Улсын аварга фермер"-ээр:

- Орхон сумын Мааньт багийн фермер Жагарын Адилбиш;

"Улсын аварга тариаланч"-аар:

- Хутаг-Өндөр сумын тариаланч Хүдэрчулууны Шижирбаатар;

"Улсын аварга тариаланч хамт олон"-оор:

- Хутаг-Өндөр сумын "Улаан буудайн эх газар" ХХК;
- Хутаг-Өндөр сумын "Гурванборхууд" ХХК;

2. Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталж, шаардагдах 9,732,000 (есөн сая долоон зуун гучин хоёр мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010034

Аймгийн Засаг даргын 2023 оны  
02 дугаар сарын 13-ны өдрийн А/84 дугаар  
захирамжийн хавсралт

ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	2	3	4	5
1	Талархал	12	82,000	984,000
2	Гарын бэлэг	12	729,000	8,748,000
	<b>Нийт</b>			<b>9,732,000</b>